

# АРЛИНГТОНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

## ОРОН СУУЦНЫ ТУСЛАМЖ

**Arlington County Department of Human Services**  
(Арлингтоны Халамж Үйлчилгээний Газар)  
2100 Washington Boulevard  
Arlington, VA 22204

Яаралтай орон байраар  
хангах (CAB) 703-228-1300  
Яаралтай орон байраар  
хангах утас 24/7 цагаар 703-228-1010

## ТҮР ОРОГНОХ БАЙР

Bridges to Independence  
түр орогнох байр 703-525-7717  
Doogways Family түр орогнох байр 703-907-0022  
Doogways гэр бүлийн хүчирхийлэлд  
ертсөн хүмүүст зориулсан байр 703-237-0881

## ХҮНСНИЙ ТУСЛАМЖ

**Arlington Food Assistance Center**  
(Арлингтоны Хүнсний  
Тусламжийн Төв) 703-845-8486  
2780 South Nelson Street  
Arlington, VA 22206

## СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД

**Arlington County Behavioral Healthcare Division**  
(Арлингтоны Сэтгэцийн Эрүүл Мэндийн Хэлтэс)  
2120 Washington Blvd., Arlington, VA 22204

Зан үйлийн эрүүл мэндийн тусламж 703-228-5150  
Яаралтай тусламж 703-228-5160

Хүүхдийн бүсийн тусламжийн алба 884-627-4747

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

**Arlington County Department of Public Health**  
(Арлингтоны Нийтийн Эрүүл Мэндийн Газар)  
2100 Washington Boulevard  
Arlington, VA 22204

Эмнэлэг 703-228-1200  
Дархлаажуулалтын клиник 703-228-1290  
Өсвөр үеийнхэнд зориулсан  
эрүүл мэндийн үйлчилгээ 703-228-1214

Arlington Pediatric Center (Арлингтоны  
Хүүхдийн Эрүүл Мэндийн Төв) 703-717-7545  
601 S. Carlin Springs Road  
Arlington, VA 22204

## ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Medicaid даатгал, TANF санхүүгийн  
тусламж, SNAP хүнсний тусламж 703-228-1350

## ЧУХАЛ ДУГААРУУД

Хүүхэд хамгаалах алба (ХХА) 703-228-1500  
Гэр бүлийн & бэлгийн  
хүчирхийлэл мэдээлэх дугаар 703-237-0881

# ТАНД АСУУЛТ эсвэл САНАЛ ХҮСЭЛТ байна уу?



Хэрэв хүүхдээ сургуульд элсүүлэн сургахад танд бэрхшээлтэй байгаа, эдийн засгийн болон бусад хүндрэл бэрхшээлээс болж Арлингтонд орон байргүй болсон эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хүнтэй холбоо бариарай:

**Барбара Фишер, Мэргэжлийн  
нийгмийн ажилтан**

Орон гэргүй хүмүүсийн зохицуулагч  
Нэмэлт алхам төсөл  
(703) 228-2585  
barbara.fisher@apsva.us

**Сайр Молина**

Захиргааны туслах ажилтан  
Нэмэлт алхам төсөл  
(зуны саруудад холбоо барих хүн)

703-228-6046  
sair.molina@apsva.us

**Вэбсайт:**

<https://www.apsva.us/student-services/homeless/>

*Сурагчид орон гэргүй болох нь зөвхөн орон сууцны асуудал биш юм. Энэ нь хүүхдийн амьдралд бүхэлд нь нөлөөлдөг. Боловсрол бол ядуурлыг таслан зогсоож, эдийн засгийн хараат бус байдалд хүрэх гол арга зам юм.*



## НЭМЭЛТ АЛХАМ ТӨСӨЛ



## Орон гэргүй хүүхэд, залуусын боловсролын хэрэгцээг хангах

Office of Student Services  
(Сурагчдад Үзүүлэх Үйлчилгээний  
Хэлтэс)  
2110 Washington Boulevard  
Arlington, VA 22204  
703-228-6046

## ТОГТВОРТОЙ, БАЙНГЫН, ЗОХИХ ОРОН БАЙРГҮЙ ХҮҮХЭД, ЗАЛУУСЫН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ

Орон гэргүй иргэдэд туслах **МкКинни-Венто** хуулиар **байнгын орон сууц байхгүйн улмаас** тохиромжгүй эсвэл түр байранд амьдарч байгаа бүх хүмүүсийг сургуульд сурах нөхцөлөөр хангадаг:

- Онцгой байдалд орогнох байр эсвэл түр байр
- Өөр боломжгүйн улмаас дэн буудал, зочид буудал эсвэл аяны талбай
- Автомашин, цэцэрлэгт хүрээлэн, нийтийн эзэмшлийн талбай, автобус эсвэл галт тэрэгний буудал эсвэл эзэнгүй байшин
- Орон сууцгүй болсон эсвэл эдийн засгийн хүндрэлийн улмаас хамаатан садан эсвэл найзынхаа гэрт амьдарч буй.

Хэдийгээр сургуулийн бүртгэл мэдээлэл нь гарын доор байхгүй байгаа ч орон гэргүй болсон хүүхэд, залуус **сургуульд сурах эрхтэй**.

Орон гэргүй хүүхдүүд өөрсдийн ашиг сонирхлынхоо дагуу анхны сургуульдаа үргэлжлүүлэн сурах, эсвэл оршин сууж байгаа газрынхаа улсын сургуульд бүртгүүлэн суралцаж болно.

**Орон гэргүй, харгалзах хүнгүй хүүхэд багачууд** мөн эдгээр эрхийг эдэлнэ.



## ЭЦЭГ ЭХЧҮҮД ЮУ ХИЙЖ БОЛОХ ВЭ?



- Сургуулийн нийгмийн ажилтан, захирал, зөвлөх, багш эсвэл сургуулийн сувилагчтай орон байрны нөхцөлийнхөө талаар ярилцаарай.
- Танай гэр бүл эсвэл хүүхэд нүүвэл сургуульд мэдэгдэж, шинэ хаягаа өгөөрэй.
- Танай хүүхдийн авах боломжтой тусламж дэмжлэгийн талаар асуугаарай.
- Таны оршин сууж буй газартай ойр сургуулийн талаар мэдээлэл авахыг бодоорой.
- Боломжтой бол хүүхдээ сургуульд бүртгүүлэхдээ төрсний гэрчилгээ, сургуулийн болон дархлаажуулалтын мэдээллийг авчраарай.
- Хичээлийн хэрэгслийг хаанаас авч болох тухай асуугаарай.
- Өмнөх сургуулиас хүүхдийнхээ хувийн хэргийг шилжүүлж өгөхийг хүсээрэй.
- Арлингтоны улсын сургууль орон байргүй сурагчдад дэмжлэг тусалцаа үзүүлэхийн төлөө ажилладаг.
- Нэмэлт алхам төсөл уруу залгаарай!  
703-228-6046

## НЭМЭЛТ АЛХАМ ТӨСӨЛ ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

- Хүүхдээ сургуульд бүртгүүлэхэд эцэг эхэд туслах.
- Тухайн дүүрэгтээ хүүхдээ сургахад нь унаа тээврийн хувьд эцэг эхэд туслах.
- Сургууль дээр сурагчдыг өглөөний цай, өдрийн хоолны хөтөлбөрт хамруулахад туслах.
- Сурагчдад үнэгүй давтлага сургалтын үйлчилгээ үзүүлэх.
- Шаардлагатай бол хичээлийн хэрэгсэл, материалаар хангах.
- АУС-ийн уртасгасан өдрийн сургалтад хамрагдахад туслах.
- Халамжийн үйлчилгээ авахад айл өрхөд туслах.
- Нэг сургуулиас нөгөө уруу амар хялбар шилжихэд сурагчдад туслах.
- Эрүүл мэндийн болон сургуулийн бүртгэл мэдээллийг боловсруулахад туслах.
- Орон гэргүйчүү иргэдэд туслах МкКинни-Венто хуулийн дагуу орон гэргүй сурагчдын хэрэгцээний талаар иргэдэд мэдээлэл боловсрол олгоход туслах.

